



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/93

Хэрлэн сум

Зөвлөх үйлчилгээнд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2 дугаар хуралдааны “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 6 дугаар тогтоолын хавсралтын 2.4.12, 2023 оны 12 дугаар сарын 05-ны “Аймгийн 2024 оны Төсөв батлах тухай” хорин гуравдугаар Хуралдааны 2 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн Төр-Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх зорилтын хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн үйлчилгээний стандартыг сайжруулахад чиглэсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд 10,000,000 (арван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ